

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2012 ОНЫ 3 ДУГААР
УЛИРАЛД ИРҮҮЛСЭН ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭНИЙ
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2012.09.30

Улаанбаатар хот

НЭГ. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭНИЙ ИРЦИЙН ТАЛААР:

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.1 дэх заалтыг үндэслэн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 02 дугаар сарын 28 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д 7 заалт бүхий 2.6 дахь хэсгийг болон гадаад валютын арилжааны мэдээ гаргах хавсралтуудыг тус тус шинээр нэмж, “Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа” эрхлэн явуулдаг банк бус санхүүгийн байгууллага /цаашид ББСБ гэх/-ууд эдгээр хавсралтын дагуу мэдээг дараа сарын 10-ны өдрийн дотор гаргаж, Хороонд ирүүлж байхыг заасан. Үүний дагуу гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудаас гадаад валютын арилжааны мэдээг сар бүр гаргуулан авч, улирлаар нэгтгэн Хорооны удирдлагуудад танилцуулж, нэгтгэлийг товч байдлаар Монголбанкинд хүрүүлж байгаа болно.

Манай улсын хэмжээнд 2012 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй 205 ББСБ байгаагийн 91 ББСБ нь буюу 44.4 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 91 ББСБ-ын 38 нь буюу 41.8% нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, 57 нь буюу 58.2% нь энэхүү үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны мэдээ ирүүлбэл зохих нийт 91 ББСБ-ын 61 нь ирүүлж, 30 нь ирүүлээгүй бөгөөд мэдээний ирц 67.0 хувь байна.

/Гадаад валютын арилжааны мэдээний ирцийн талаарх мэдээллийг ББСБ тус бүрээр гаргаж, танилцуулгад хавсаргав/.

Мэдээ ирүүлээгүй 30 ББСБ-ын 21 нь тус хугацаанд энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулаагүй бөгөөд цаашид явуулна гэсэн тайлбар бүхий албан бичгийг ирүүлсэн, 9 нь гадаад валютын арилжааны мэдээ болон ямар нэгэн тайлбар бичиг ирүүлээгүй байна. Тодруулбал:

- Зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 37 ББСБ-аас 35 нь мэдээгээ ирүүлж, 2 нь ирүүлээгүй бөгөөд эдгээр нь үйл ажиллагаагаа явуулаагүй тухай албан бичиг ирүүлсэн.

- Гадаад валютын арилжааны үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй 54 ББСБ-ын 26 нь мэдээгээ ирүүлж, 28 нь

Гадаад валютын арилжааны 2012 оны 3 дугаар улирлын мэдээний нэгтгэл

ирүүлээгүй бөгөөд эдгээрийн 19 нь тус тайлант хугацаанд гадаад валютын арилжаагаар гүйлгээ хийгээгүй тухай албан бичгийг ирүүлж, 9 нь үйл ажиллагаа явуулсан эсэх талаар огт мэдээлээгүй байна.

Эндээс үндэслэн үйл ажиллагаа явуулаагүй талаар албан бичгээр мэдээлсэн 21 ББСБ-ыг тус мэдээг ирүүлсэнд оруулан тооцож үзвэл гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай 91 ББСБ-ын 82 нь буюу 90.1 хувь нь мэдээгээ ирүүлсэн байна гэж үзэхээр байна.

Тус Хорооноос тайлант 3 дугаар улиралд нийт 8 ХХК-д банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосны 2-т нь банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгожээ. Үүнд:

- Хорооны 2012 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 249 дүгээр тогтоолоор □Чингис хаан ресорс□ ХХК-д зөвхөн гадаад валютын арилжааны;

- 2012 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 270 дугаар тогтоолоор □Эм даблви кредит□ ХХК-д зээл, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх эрхлэхийг тус тус зөвшөөрчээ.

Гадаад валютын арилжааны мэдээ ирүүлсэн ББСБ-уудын тоонд тус тайлант хугацаанд гадаад валютын арилжаагаар гүйлгээ хийгээгүй тухайгаа албан бичгээр мэдээлсэн 21 ББСБ-ыг оруулж тооцвол мэдээний ирцийн тоо 86 болж, 94.5 хувьтай гарч байна.

Мэдээ ирүүлсэн нийт 61 ББСБ нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Мэдээний ирцийг өмнөх улирлуудтай харьцуулан үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	МЭДЭЭ ИРҮҮЛЭ Х ББСБ- ЫН ТОО	МЭДЭЭ ИРҮҮЛСЭ Н ББСБ- ЫН ТОО	МЭДЭЭНИЙ ИРЦ	ӨСӨЛТ, БУУРАЛТ ХУВИАР <i>/өмнөх улирлаас /</i>
1	2010 оны 1 дүгээр улирал	112	31	40.4%	0.0%
2	2010 оны 2 дугаар улирал	110	43	39.0%	-1.4%
3	2010 оны 3 дугаар улирал	109	48	44.0%	5.0%
4	2010 оны 4 дүгээр улирал	95	71	74.7%	30.7%
5	2011 оны 1 дүгээр улирал	93	73	78.5%	3.8%
6	2011 оны 2 дугаар улирал	98	60	61.2%	-17.3%
7	2011 оны 3 дугаар улирал	96	52	54.2%	-7.0%
8	2011 оны 4 дүгээр улирал	92	67	71.7%	17.5%
9	2012 оны 1 дүгээр улирал	91	68	74.7%	3.0%
10	2012 оны 2 дугаар улирал	91	66	72.5%	-2.2%
11	2012 оны 3 дугаар улирал	91	61	67.0%	-5.5%

Гадаад валютын арилжааны 2012 оны 3 дугаар улирлын мэдээний нэгтгэл

Дээрх хүснэгтээс үзэхэд тус хугацаанд мэдээ ирүүлсэн ББСБ-ын тоо 2010 оны 3 дугаар улирлынхаас 13-аар, 2011 оны 3 дугаар улирлынхаас 5-аар тус тус өсч, өмнөх улирлынхаас 5-аар буурсан үзүүлэлттэй байна. Мэдээний ирцийг хувиар тооцож үзвэл:

- 2010 оны 1,2,3,4 дүгээр улиралд 39.0% -с 74.7%;
- 2011 оны 1,2,3,4 дүгээр улиралд 54.2% -с 78.5% байсан бол
- 2012 оны 1 дүгээр улиралд 74.7% болж 2011 оны 4 дүгээр улирлынхаас 3.0%-иар өссөн;
- 2012 оны 2 дугаар улиралд 72.5% болж 2011 оны 1 дүгээр улирлынхаас 2.2%-р буурсан;
- 2012 оны 3 дугаар улиралд 67.0% болж 2012 оны 2 дугаар улирлынхаас 5.5%-р буурсан; - 2011 оны 4 дүгээр улирлынхаас 4.7%-иар буурсан үзүүлэлттэй гарч байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 91 ББСБ байгаа нь өмнөх улирлынхтай ижил байгаа боловч мэдээний ирц буурсан үзүүлэлттэй байна.

ХОЁР. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА БОЛОН ВАЛЮТЫН ХАНШИЙН ТАЛААР:

Энэхүү нэгтгэлийг ББСБ-уудаас ирүүлсэн гадаад валютын арилжааны мэдээнд үндэслэн хийхдээ тэдгээрийн иргэн, хуулийн этгээдээс худалдан авсан гадаад валютын болон худалдсан гадаад валют бүрийн ханшийг ам.доллар болон Монгол улсын үндэсний валют төгрөгт хөрвүүлсэн дүнгээр тус тус тооцсон болно.

Худалдан авсан болон худалдсан гадаад валютуудыг төгрөгт хөрвүүлсэн дүнгээр тооцож, өмнөх улиралтай харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

1. Худалдаж авсан нийт гадаад валют:

д/ д	ВАЛЮТЫН НЭР	УЛИРАЛ				
		2010 ОНЫ III улирал	2011 ОНЫ III улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/ /өмнөх үеэс/	2012 ОНЫ III улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/ /өмнөх оны мөн үеэс/
1	ТӨГРӨГ	199,830,846.6	149,731,203.9	-50,099,642.7	363,191,209.0	213,460,005.1
2	АМ. ДОЛЛАРТ ШИЛЖҮҮЛСЭН ДҮНГЭЭР	149,735.0	120,707.4	-29,027.6	266,070.9	145,363.5
3	ДУНДАЖ ХАНШ	1334.56	1,240.45	-94.11	1,365.02	124.57

Худалдаж авсан нийт гадаад валютын төгрөгт хөрвүүлсэн мөнгөн дүнг өмнөх онуудын мөн үеүдтэй харьцуулж үзэхэд:

Гадаад валютын арилжааны 2012 оны 3 дугаар улирлын мэдээний нэгтгэл

- 2011 оны 3 дугаар улиралд 2010 оны мөн үеэс 50,099,642.7 мянган төгрөгөөр буюу 25.1 хувиар, ам.долларт хөрвүүлсэн дүнгээр 29,027.6 мянган ам.доллараар буюу 19.4 хувиар буурсан бол;

- 2012 оны 3 дугаар улиралд 2010 оны мөн үеэс 163,360,362.4 мянган төгрөгөөр буюу 45.0 хувиар, ам.долларт хөрвүүлсэн дүнгээр 116,335.9 мянган ам.доллараар буюу 43.7 хувиар тус тус өсч;

- 2012 оны 3 дугаар улиралд 2011 оны мөн үеэс 213,460,005.1 мянган төгрөгөөр буюу 58.8 хувиар, ам.долларт хөрвүүлсэн дүн 145,363.5 мянган ам.доллараар буюу 54.6 хувиар өссөн үзүүлэлттэй гарч байна.

Нэгтгэлд ББСБ-уудын худалдаж авсан нийт гадаад валют тус бүрийн ханшийг ам.долларт хөрвүүлсэн дүнгээр тооцож, ам.долларын дундаж ханшийг тооцож үзэхэд 1,365.02 төгрөг болж байгаа нь:

- 2011 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеийнхээс /1,240.45₮:1,334.56₮/ 94.11 төгрөгөөр буюу 7.1 хувиар буурсан бол;

- 2012 оны 3 дугаар улиралд 2010 оны мөн үеийнхээс /1,334.56₮:1,365.02₮/ 30.46 төгрөгөөр буюу 2.2 хувиар өссөн;

- 2012 оны 3 дугаар улиралд 2011 оны мөн үеийнхээс /1,240.45₮:1,365.02₮/ 124.57 төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн үзүүлэлттэй гарч байна.

2. Худалдсан нийт гадаад валют:

/МЯНГАН ТӨГРӨГӨӨР/

д/д	ВАЛЮТЫН НЭР	УЛИРАЛ				
		2010 ОНЫ III улирал	2011 ОНЫ III улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/ <i>Юмлох үеэс/</i>	2012 ОНЫ III улирал	ӨСӨЛТ, БУУРАЛТ /+;-/ <i>Юмлох үеэс/</i>
1	ТӨГРӨГ	213,083,678.3	157,659,283.2	-55,424,395.1	285,348,224.4	127,688,941.2
2	АМ. ДОЛЛАРТ ШИЛЖҮҮЛСЭН ДҮНГЭЭР	159,183.1	126,481.5	-32,701.6	208,202.0	81,720.5
3	ДУНДАЖ ХАНШ	1338.61	1,246.50	-92.11	1,370.54	124.04

Худалдсан нийт гадаад валютын төгрөгт хөрвүүлсэн мөнгөн дүнг өмнөх онуудын мөн үеүдтэй харьцуулж үзэхэд:

- 2011 оны 3 дугаар улиралд 2010 оны мөн үеэс 55,424,395.1 мянган төгрөгөөр буюу 26.0 хувиар, ам.долларт хөрвүүлсэн дүнгээр 29,027.6 мянган ам.доллараар буюу 20.5 хувиар буурсан бол;

Гадаад валютын арилжааны 2012 оны 3 дугаар улирлын мэдээний нэгтгэл

- 2012 оны 3 дугаар улиралд 2010 оны мөн үеэс 72,264,546.1 мянган төгрөгөөр буюу 25.3 хувиар, ам.долларт хөрвүүлсэн дүнгээр 49,018.9 мянган ам.доллараар буюу 23.5 хувиар тус тус өсч;

- 2012 оны 3 дугаар улиралд 2011 оны мөн үеэс 127,688,941.2 мянган төгрөгөөр буюу 44.7 хувиар, ам.долларт хөрвүүлсэн дүн 81,720.5 мянган ам.доллараар буюу 39.3 хувиар өссөн үзүүлэлттэй гарч байна.

Нэгтгэлд ББСБ-уудын худалдсан нийт гадаад валют тус бүрийн ханшийг ам.долларт хөрвүүлсэн дүнгээр тооцож, ам.долларын дундаж ханшийг тооцож үзэхэд 1,370.54 төгрөг болж байгаа нь:

- 2011 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеийнхээс /1,246.50₮:1,338.61₮/ 92.11 төгрөгөөр буюу 6.9 хувиар буурсан бол;

- 2012 оны 3 дугаар улиралд 2010 оны мөн үеийнхээс /1,338.61₮:1,370.54₮/ 31.93 төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн;

- 2012 оны 3 дугаар улиралд 2011 оны мөн үеийнхээс /1,246.50₮:1,370.54₮/ 124.04 төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн үзүүлэлттэй гарч байна.

Энэхүү нэгтгэлээс үзэхэд ББСБ-уудын 2012 оны 3 дугаар улиралд худалдаж авсан нийт гадаад валютын мөнгөн дүн худалдсан нийт гадаад валютын мөнгөн дүнгээс /363,191,209.0₮-285,348,224.4₮/ 77,842,984.6 мянган төгрөг буюу 21.4 хувиар их, ам.долларт хөрвүүлснээр мөн /266,070.9₯-208,202.0₯/ 57,868.9 мянган ам.доллар буюу 21.7 хувиар их гарч байна.

Ийнхүү худалдан авсан гадаад валютын мөнгөн дүн худалдсан гадаад валютуудын дүнгээс 77,842,984.6 мянган төгрөг буюу 21.4 хувиар, 57,868.9 мянган ам.доллар буюу 21.7 хувиар тус тус их байгаа нь тус тайлант хугацаанд ББСБ-уудаас мөнгөний зах зээлд нийлүүлэх гадаад валютын нийлүүлэлтийн хэмжээ буурсан байгааг харуулж буй төдийгүй энэ нь гадаад валютын ханшийг өсөхөд нөлөөлсөн гэж үзэж байна. Тухайлбал 2012 оны 3 дугаар улирлын байдлаар нийт гадаад валютуудын ам.долларт хөрвүүлсэн ханшийн хэмжээ 2010, 2011 оны мөн үеийнхээс дунджаар 5.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Сүүлийн 2 улирлын байдлаар хийсэн нэгтгэлээс үзэхэд гадаад валютын зах зээлд нийлүүлэх хэмжээ багассаар байгааг илтгэж байгаа бөгөөд энэ нь ханш өсөхөд нөлөөлөх үндсэн нөхцөл нь болно.

Гадаад валютын арилжааны хэмжээ 2010, 2011 оны мөн үеийнхээс 2.3-39.3 хувиар өссөн байгаа нь зах зээл дээр гадаад валютын эрэлт хэрэгцээ өссөнөөр ам.долларын ханш бага багаар чангарч үүнийг даган бусад валютуудын ханш нэмэгдэж иржээ.

Энэ нь цаг агаараас хамааралтай буюу улирлын шинж чанартай /тухайлбал уул уурхай, барилга, газар тариалан гэх зэрэг/ үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудын ажил үйлчилгээний цар хүрээ тэлж, үүнийг даган мөнгөний эрэлт хэрэгцээ нэмэгдсэн, гадаадын хөрөнгө оруулагчдаас орж ирэх гадаад валютын санхүүжилт хэмжээ нэмэгдэж,

Гадаад валютын арилжааны 2012 оны 3 дугаар улирлын мэдээний нэгтгэл

гадаад валютаар төлбөр тооцоо хийдэг дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудын эрэлт хэрэгцээ өссөн зэрэгтэй холбоотой.

2011 оны 12 дугаар сард зах зээл дэх ам.долларын ханш 1,402.0 төгрөгт хүртэл өсч түүнийг даган бусад валютуудын ханш чангарснаар валютын ханшийн зөрүүнээс ашиг олох зорилготой гадаад валютын арилжаа эрхлэгчид гадаад валютыг худалдан авахаас илүү худалдсан.

Гэтэл 2012 оны 2,3 дугаар улиралд гадаад валютыг худалдан авсан нь худалдахаасаа илүү байна. Үүнд Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороонд байрлах Төмөрчний гудамжинд үйл ажиллагаа явуулдаг ББСБ-уудын ажлын байр газарт орсон нь нөлөөлсөн байх талтай. Нэгтгэлээс үзэхэд:

1. Худалдаж авсан нийт валютын 14.6%-ийг хуулийн этгээдээс, 85.4%-ийг иргэдээс худалдан авч;
2. Худалдсан нийт валютын 7.8%-ийг хуулийн этгээдэд, 92.2%-ийг иргэдэд тус тус худалдсан байгаагаас үзэхэд ББСБ-ууд нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаагаар ихэвчлэн иргэдэд үйлчилж ирснийг харуулж байна.

Тайлант 3 дугаар улиралд ББСБ-ууд гадаад валютын арилжааны үйл ажиллагаагаар давхардсан тоогоор нийт 648,539,432.4 мянган төгрөгийн буюу 474,272.9 мянган ам.долларын гүйлгээ хийгдсэн байгаагийн 43.9 хувь нь гадаад валютыг худалдаж авсан гүйлгээ, 56.1 хувь нь гадаад валютыг худалдсан гүйлгээ байна.

Гадаад валютын ялангуяа ам.долларын албан болон зах зээлийн ханшийг 2012 оны 3 дугаар улирлын байдлаар харьцуулж үзвэл Монголбанкнаас зарласан албан ханш /7,8,9 сарын дундаж/-ийн дундаж 1\$=1,375.19₮ байсан бол ББСБ-уудын худалдан авсан болон худалдсан ханшийн дундаж 1,367.78 төгрөг байв. Энэ нь албан ханшаас 7.41 төгрөгөөр бага дүнтэй гарч байна.

ББСБ-уудын гадаад валютын арилжаанд түгээмэл ордог гадаад валютуудын зах зээл дэх ханшийн өөрчлөлт /хэлбэлзэл/-ийг 2010, 2011 оны жилийн эцэс, 2012 оны 3 дугаар улирлын байдлаарх үзүүлэлтүүдтэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/ТӨГРӨГӨӨР/

Д/д	ВАЛЮТЫН ТӨРӨЛ		ХАНШИЙН ДУНДАЖ ДҮН			
			2010 оны IV улирал	2011 оны IV улирал	2012 оны II улирал	2012 оны III улирал
1	АНУ доллар	USD	1,270.00	1,322.53	1,322.53	1,367.78
2	Английн фунт	GBP	1,930.96	2,097.24	2,097.24	2,184.33
3	Евро	EUR	1,713.68	1,710.78	1,710.78	1,726.64

Гадаад валютын арилжааны 2012 оны 3 дугаар улирлын мэдээний нэгтгэл

4	БНХАУ-ын юань	CNY	188.00	209.86	209.86	216.14
5	БНСУ-ын вон	KRW	1.04	1.37	1.37	1.47
6	ОХУ-ын рубль	RUB	41.20	42.86	42.86	42.85
7	Японы иен	JPY	15.50	18.35	18.35	18.36

Гадаад валютын ханшийн хэлбэлзлийг авч үзүүлвэл дараах байдалтай байна. Үүнд:

төгрөгөөр

Д/д	ВАЛЮТЫН ТӨРӨЛ		ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ /ӨСӨЛТ +; БУУРАЛТ -/			
			2010 оны IV улирал	2011 оны IV улирал	2012 оны II улирал	2012 оны III улирал
1	АНУ доллар	USD	-	80.83	-29.55	45.25
2	Английн фунт	GBP	-	82.72	21.19	87.09
3	Евро	EUR	-	10.68	-56.25	15.86
4	БНХАУ-ын юань	CNY	-	10.75	-0.49	6.28
5	БНСУ-ын вон	KRW	-	0.24	0.19	0.10
6	ОХУ-ын рубль	RUB	-	0.24	-1.42	-0.01
7	Японы иен	JPY	-	2.57	-0.1	0.01

Дээрх хүснэгтээс үзэхэд 2012 оны 3 дугаар улиралд өмнөх улирлынхаас АНУ-ын ам.доллар 45.25 төгрөг, Евро 87.09 төгрөг, Японы иен 0.01 төгрөг, Хятадын юань 6.28 төгрөгөөр, Английн фунт 87.09 төгрөг, БНСУ-ын вон 0.10 төгрөгөөр тус тус өсч, Оросын рубль 0.01 төгрөгөөр буурсан байна. Үүнээс үндэслэн нийт гадаад валют тус бүрийн хоорондын ханшийн зөрүү харьцангуй тогтуун байсан төдийгүй огцом хэлбэлзэл гараагүй байна.

Гадаад валютын арилжааны мэдээний нэгтгэлээс үзэхэд тайлант хугацаанд нийт /363,191,209.0₮+285,348,224.4₮/ 648,539,433.4 мянган төгрөг буюу /266,070.9+208,202.0/ 474,272.9 мянган ам.долларын арилжаа хийсний /64,529,525.0+81,292,203.5/ 145,821,172.5 мянган төгрөг буюу /47,273.8+59,314.2/ 106,588.0 мянган ам.доллар нь нийт валютын 22.5 хувийг, /44,492,264.2+47,735,594.7/ 92,227,858.9 мянган төгрөг буюу /32,594.7+34,829.9/ 67,424.6 мянган ам.долларын евро нь нийт валютын 14.2 хувийг, /125,104,224.7₮+144,172,618.6₮/ 269,276,843.3 мянган төгрөг буюу /91,650.3+105,194.4/ 196,844.7 мянган ам.долларын юань нийт валютын 41.5 хувийг юань эзэлж байгаа бөгөөд үлдсэн хувийг бусад валют эзэлж байна.

ГУРАВ. САНАЛ, ДҮГНЭЛТ

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулдаг ББСБ-уудын /тооны/ судалгааг гаргаж тэдгээрийг энэхүү үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхэлдэг эсэх болон дангаар эрхлэн явуулдагаар нь тус тус ангилан холбогдох тоон үзүүлэлтүүдийг хариуцсан хянан шалгагч нартай тулгаж тохируулсан болно.

Гадаад валютын арилжааны 2012 оны 3 дугаар улирлын мэдээний нэгтгэл

Нэтгэлээр тайлант хугацаанд гадаад валютын арилжааны мэдээ ирүүлбэл зохих нийт 91 ББСБ-ын 61 нь ирүүлж, 30 нь ирүүлээгүй бөгөөд мэдээний ирц 67.0 хувь байна.

Мэдээний ирц 67.0 хувьтай байгаа нь өмнөх улирлаас 5.5 хувиар буурсан байна. Энэхүү үзүүлэлт нь цаашид гадаад валютын арилжааны мэдээний ирцийг нэмэгдүүлэх улмаар гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бүх ББСБ-уудаас энэхүү мэдээг сар бүр бүрэн гаргуулж авахын зэрэгцээ түүний үнэн зөв бодитой эсэхэд хяналт тавих шаардлагатай байгааг илтгэж байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ууд нь гадаад валютын ханшийн зөрүүн дээр ашиг олох зорилготой байдагтай уялдан тус ББСБ-уудын мөнгөн хөрөнгө зах зээл дээрх эрэлт хэрэгцээтэй уялдан өдөрт хэдэн ч удаа эргэлтэд орох тохиолдол гардаг. Иймээс гадаад валютын худалдсан болон худалдан авсан мөнгөний дүн өндөр дүнтэй гардаг болно.

Гадаад валютын арилжааны мэдээг цахим хэлбэрээр авч байх ажиллагааг Хорооны Мэдээлэл технологийн хэлтэстэй хамтран гүйцэтгэж, 2011 оны 8 дугаар сараас мэдээг туршилтын байдлаар /цахим хэлбэрээр/ авч эхэлсэн. Хороо нь гадаад валютын арилжааны мэдээг цахим хэлбэрээр авах болсон талаарх мэдээлэл болон арилжааны мэдээг цахим хэлбэрээр хэрхэн ирүүлж байх тухай ажиллагааны заавар, зөвлөмжийг албан бичгээр гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ тус бүрт хүргүүлснээс гадна Хорооны вэб сайт дээр байрлуулсан.

Үүний дагуу гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт ББСБ-уудыг арилжааны мэдээгээ сар бүр, бүрэн цахим хэлбэрээр ирүүлж байхыг хариуцсан хянан шалгагч нар нь утсаар ярьж, шаардан цахим болон хэвлэмэл хэлбэрээр авч байна. Цахим хэлбэрээр мэдээгээ ирүүлж буй ББСБ-уудын тоо сараас сард нэмэгдэж байгаа хэдий ч одоогийн байдлаар бүрэн хамрагдаагүй байна. Иймд цахим хэлбэрээр мэдээгээ ирүүлэх ББСБ-уудын тоог нэмэгдүүлэх шаардлагатай.

Мэдээг цахим хэлбэрээр ирүүлсэн ББСБ-уудын тоог авч үзвэл:

- 2011 оны 8 дугаар сард 15 ББСБ;
- 2011 оны 9 дүгээр сард 12 ББСБ;
- 2011 оны 10 дугаар сард 31 ББСБ;
- 2011 оны 11 дүгээр сард 41 ББСБ;
- 2011 оны 12 дугаар сард 39 ББСБ;
- 2012 оны 1 дүгээр улиралд 36 ББСБ;
- 2012 оны 2 дугаар улиралд 34 ББСБ;
- 2012 оны 3 дугаар улиралд 31 ББСБ.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулдаг ББСБ-ууд нь бэлэн мөнгөөр арилжаа хийдэг учраас гадаад валютын арилжааны мэдээг бүх ББСБ-уудаар сар бүр, бүрэн гаргуулан авч, нэгтгэлд хамруулж байх нь мөнгө санхүүгийн зах зээл дээр эргэлдэж буй бэлэн мөнгөний тоо хэмжээг бүрэн тодорхой гаргахад чухал ач холбогдолтой.

Гадаад валютын арилжааны 2012 оны 3 дугаар улирлын мэдээний нэгтгэл

Мэдээний ирц, үнэн бодит байдал нь мөнгө санхүүгийн зах зээл дээр арилжаалагдаж буй гадаад валютын нэр төрөл түүний тоо хэмжээ, ханш, ханшийн хэлбэлзэлийн талаарх мэдээллийг тодорхой харуулах юм. Энэ нь гадаад валютын ханшийн өөрчлөлтүүд манай улсын үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид хэрхэн нөлөөлж буй эсэхийг тодорхойлоход төдийгүй мөнгөний бодлогод чухал үүрэг гүйцэтгэнэ.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР